



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/443

Хэрлэн сум

Хаврын тариалалт болон намрын ургацын баланс тогтоох, тариалангийн бүс нутагт хяналт шалгалтаар ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гуравдугаар хуралдааны 04, 05 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан "Хаврын тариалалт болон намрын ургацын баланс тогтоох, тариалангийн бүс нутагт хяналт шалгалтаар ажиллах" ажлыг 2025 оны 06 дугаар сарын 27-оос 07 дугаар сарын 05-ыг хүртэл, 2025 оны 08 дугаар сарын 10-аас 2025 оны 08 дугаар сарын 21-ийг хүртэл Хэрлэн, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дадал, Норовлин, Батноров сумд болон Гурванбаян, Өлзийт, Тахилгат тосгодод ажиллахад 2,000,000 (хоёр сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Хаврын тариалалт болон намрын ургацын баланс тогтоох, тариалангийн бүс нутагт хяналт шалгалтаар ажиллах замын зардлын тооцоог нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Үнэнбат)-т, тус захирамжийн хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантөмөр)-д, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

08
A1473

Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 21 ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Явах (км)	Шаардагдах шатахуун (л)	Шатахууны нэг бүрийн үнэ (төг)	Шатахууны нийт үнэ (төг)
1	Тариалалтын чанарыг соёололтоор шалгаж хүлээн авах ажлын шатахуун	1953	312.5	3200	1.000.000
2	Ургацын баланс тогтоох, ургамал хамгаалал хорио цээрийн хяналт хийх шатахуун	1953	312.5	3200	1.000.000
Нийт үнэ:					2.000.000